

# ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

*2025 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлан*

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГАЗАР**

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV  
байр. Утас: 51-261668 Цахим шуудан: nbfi@frc.mn

## Агуулга

Хүснэгтийн жагсаалт .....	3
Зургийн жагсаалт .....	3
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН.....	4
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ .....	5
ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	6
Батлан даалт, байршил.....	7
Батлан даалт, зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэл.....	9
Зээлдүүлэгч болон батлан даалтын эх үүсвэр .....	9
Зээлийн болон батлан даалтын чанар .....	10
ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ.....	13
САНАЛ, ДҮГНЭЛТ .....	14

## Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Зээл, батлан даалтын дүн, тоо (аймгаар)сая.төг.....	8
Хүснэгт 2 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт .....	13

## Зургийн жагсаалт

Зураг 1 Нийт хөрөнгө (тэрбум.төг) .....	5
Зураг 2 Эх үүсвэрийн бүтэц (хувиар).....	5
Зураг 3 Нийт орлого, цэвэр ашиг (тэрбум.төг) .....	5
Зураг 4 Нийт орлого, зардал (тэрбум.төг) .....	2
Зураг 5 Зээл, батлан даалтын үлдэгдэл (тэрбум.төг).....	6
Зураг 6 Батлан даалтын хүсэлтийн тоо .....	6
Зураг 7 Батлан даалтын дундаж хэмжээ (сая.төг).....	7
Зураг 8 Зээл, батлан даалтын дүн, тоо (дүүргээр) сая.төг.....	7
Зураг 9 Батлан даалтын тоо (бүс нутгаар).....	8
Зураг 10 Батлан даалтын хэмжээ, тоо (бүс нутгаар) .....	8
Зураг 11 Батлан даалтын бүтэц (үйл ажиллагааны чиглэлээр) .....	9
Зураг 12 Батлан даалтын хэмжээ (банкаар).....	10
Зураг 13 Батлан даалтын бүтэц (эх үүсвэрээр) .....	10
Зураг 14 Батлан даалтын чанар (хувиар) .....	10
Зураг 15 Зээлийн чанар (хувиар) .....	10
Зураг 16 Чанаргүй батлан даалтын хувь, зээлдэгчдийн тоо .....	11
Зураг 17 Үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын дүн, тоо .....	<b>1Error! Bookmark not defined.</b>
Зураг 18 Төлөгдсөн авлагын хэмжээ.....	<b>1Error! Bookmark not defined.</b>
Зураг 19 Чанаргүй батлан даалтын үлдэгдэл (үйл ажиллагааны чиглэлээр).....	12

## **ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ХУУЛЬ, ЭРХЗҮЙН ОРЧИН**

Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийг баталж, 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Зээлийн батлан даалтын сан байгуулагдсан. Зээлийн батлан даалтын сан нь барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, хуулийн этгээд, жижиг дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

Засгийн газраас хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд 2021 онд Улсын Их Хурлаас тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 9 дүгээр зүйлийн 9.1.3-т “төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогод нийцүүлэн Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа иргэн, хуулийн этгээдийн урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргах” гэж заасан. Үүний дагуу 2023 оноос эхлэн 21 аймаг болон Улаанбаатар хотын Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд банк, санхүүгийн байгууллагаас орон сууцны ипотекийн 6 хувийн хүүтэй зээл авахыг хүссэн, ипотекийн зээлийн урьдчилгаа төлбөрийн дутагдалтай этгээдэд урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувьд батлан даалт гаргаж эхэлсэн.


Мөн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар Зээлийн батлан даалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т “уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Засгийн газраас баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зорилгоор банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд урьдчилгаа, барьцаа хөрөнгийн 100 хүртэлх хувьд батлан даалт гаргах.” гэж нэмсэн. Үүний дагуу Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын 2.2.2 дахь заалтыг “Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх хоршооны гишүүн малчинд гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь банк санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 100 хүртэлх хувьд, бусад төрлийн нэг зээлдэгч болон түүний холбогдох этгээдэд гаргах зээлийн батлан даалтын хэмжээ нь банк санхүүгийн байгууллагаас авах тухайн зээлийн 60 хүртэл хувь буюу сангийн өөрийн хөрөнгийн 10 хувиас хэтрэхгүй” гэж хуульд нийцүүлж өөрчлөн найруулсан.

Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 18 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн дүрэмд 3 заалтыг өөрчлөн найруулахаар, 9 заалтад нэмэлт өөрчлөлт оруулахаар шийдвэрлэж, Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлтээ ирүүлсэн ба Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хурлын тэмдэглэлээр Зээлийн батлан даалтын сангийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн.

## ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

2025 оны жилийн эхний улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 303.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.4% хувиар буюу 10.1 тэрбум төгрөгөөр өссөн ба үүнд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт голлон нөлөөлж байна./Тус тайлангийн нэгтгэлийг төрийн аудитын байгууллагаас зээлийн батлан даалтын санд аудит хийсэн дүнгээр гаргасан ба жилийн эцсийн дүнд өөрчлөлт орсон нь Сангийн санхүүгийн тайланд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан цаглабарт хугацаанд, “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь” МОН-3338 төслийн санхүүгийн тайланд 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд төрийн аудитын байгууллага аудит хийдэг ба тус хугацаа нь СЗХ-нд хүргүүлж байгаа жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хугацаанаас зөрдөг бөгөөд аудитаар санхүүгийн тайланд залруулга хийх тохиолдол гардгаас шалтгаалсан болно./


Зураг 1 Нийт хөрөнгө (тэрбум.төг)



Тайлант үеийн Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг бүтцээр нь задалж үзвэл 66.8 хувийг өр төлбөр, 33.2 хувийг цэвэр хөрөнгө бүрдүүлж байна. Нийт өр төлбөрийн 2.88 хувь нь богино хугацаат


өр төлбөр бол үлдсэн 97.12 хувь нь урт хугацаат зээл, урт хугацаат зээлийн хүүгийн өглөг байна.

Зураг 2 Эх үүсвэрийн бүтэц (хувиар)




Тайлант үеийн нийт орлого 2.76 тэрбум төгрөгт хүрсэн ба энэ нь өмнөх оны мөн үеэс 1.4 дахин их буюу 756 гаруй сая төгрөгөөр өссөн үзүүлэлт юм. Харин цэвэр ашгийн дүн -11.4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны үетэй харьцуулахад 5 дахин бага буюу 9.1 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 3 Нийт орлого, цэвэр ашиг (тэрбум.төг)



Нийт орлогын 69.6% хувийг хадгаламжийн хүүгийн орлого, 30.4% хувийг батлан даалтын шимтгэл, хураамжийн орлого бүрдүүлж байгаа ба тайлант үеийн хугацаанд ямар нэг төсөл хэрэгжүүлээгүй тул нийт зардлыг 100 хувь ерөнхий удирдлагын зардал эзэлж байна.

Зураг 4 Нийт орлого, зардал (тэрбум.төг)



## ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2025 оны эхний улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сантай 11 банк, 5 банк бус санхүүгийн байгууллага хамтран ажиллах гэрээтэй бөгөөд тайлант хугацаанд нийт 11 банкны 15,240 зээлдэгчдэд 595.7 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна.


Зураг 5 Зээл, батлан даалтын үлдэгдэл (тэрбум.төг)



Тайлант үеийн нийт батлан даасан зээлийн үлдэгдэл 782.8 тэрбум төгрөг байгаа нь 2024 оны мөн үеэс 3.5 дахин, батлан даалтын үлдэгдэл 447.6 тэрбум төгрөг байгаа нь 4.1 дахин өссөн үзүүлэлт бөгөөд нийт зээлийн үлдэгдлийн 57.2 хувийг Сангаас батлан даасан байна.


Энэ оны эхний улирлын байдлаар батлан даалтын нийт 841 хүсэлт ирүүлснийг 100% хувь батлан даах шийдвэр гаран зөвшөөрөгдсөн байна. 2025 оны жилийн эхний улирлын эцсийн байдлаар ирүүлсэн хүсэлтийн тоо нь 2024 оны мөн үеэс 4.9 дахин их байгаа нь Монгол Улсын Засгийн газраас баталсан “Төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлого” болон “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд батлан даалт гаргуулах сонирхолтой иргэдийн хүсэлт голлон нөлөөлжээ.

Зураг 6 Батлан даалтын хүсэлтийн тоо



2025 оны жилийн эхний улирлын байдлаар нийт 841 зээлдэгчдийн 36.5 тэрбум төгрөгийн зээлд 21.2 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь 2024 оны мөн үеэс 4.9 дахин өссөн дүн юм. Нэг батлан даалтын дундаж хэмжээг тооцвол 2025 оны байдлаар 25.2 сая төгрөг байгаа нь өмнөх 4 жилийн дундажтай харьцуулахад 14.3 дахин бага дүн юм. Үүнд хоршооны гишүүн малчдад гаргасан батлан даалт голлон нөлөөлж байгаа ба нийт 782 малчдын зээлийн батлан даалтыг энэ оны эхний улиралд зөвшөөрсөн бөгөөд нэг малчинд олгосон дундаж зээлийн хэмжээ 34 сая төгрөг, батлан даалтын дүн 23.7 сая төгрөг байна. Харин Улаанбаатар хотын хүрээнд нэг батлан даалтын дундаж хэмжээ 237.4 сая төгрөг байгаа бол орон нутгийн хувьд 23.5 сая төгрөг байна.

Зураг 7 Батлан даалтын дундаж хэмжээ (сая.төг)




Тайлант үеийн хугацаанд Улаанбаатар хотын 7 зээлдэгчийн 3.6 тэрбум төгрөгийн зээлд 1.7 тэрбум төгрөгийн, орон нутгийн 834 зээлдэгчийн 32.9 тэрбум төгрөгийн зээлд 19.6 тэрбум төгрөгийн батлан даалт тус тус гаргасан байна.

### Батлан даалт, байршил


2025 оны байдлаар нийслэлийн дараах 3 дүүрэгт батлан даалт гаргасан ба Хан-Уул дүүрэгт хамгийн их буюу 1.2 тэрбум төгрөгийн батлан даалт гаргажээ. Сонгинохайрхан дүүргийн 2 зээлдэгчийн 392.9 сая төгрөгийн батлан даалт нь АХБ төсөлд гаргасан батлан даалт байна. Нийслэлийн 7 зээлдэгчийн 4 зээлдэгч нь АХБ төсөлд хамрагдсан иргэд, 2 зээлдэгч нь “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий малчид бол үлдсэн 1 зээлдэгч нь үйлдвэрлэл, үйлчилгээ болон бусад төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд байна.

Зураг 8 Зээл, батлан даалтын дүн, тоо (дүүргээр) сая.төг




Тайлант хугацаанд гаргасан батлан даалтыг бүс нутгаар задалж үзвэл хангайн бүсэд хамгийн их буюу 551 зээлдэгчийн 20.8 тэрбум төгрөгийн зээлд 12.7 тэрбум төгрөгийн батлан даалт, баруун бүсэд хамгийн бага буюу 94 зээлдэгчийн 3.4 тэрбум төгрөгийн зээлд 1.9 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. Орон нутагт гаргасан нийт батлан даалтын 0.6 хувь нь хуулийн этгээдэд, үлдсэн 99.4 хувь нь иргэдэд гаргасан батлан даалт байна.

Зураг 9 Батлан даалтын тоо (бүс нутгаар)



Баруун бүс	Хангайн бүс	Төв бүс	Зүүн бүс
<b>3.4 тэрбум.төг</b> хэмжээтэй зээлд	<b>20.8 тэрбум.төг</b> хэмжээтэй зээлд	<b>4.0 тэрбум.төг</b> хэмжээтэй зээлд	<b>4.7 тэрбум.төг</b> хэмжээтэй зээлд
<b>1.9 тэрбум.төг</b> батлан даалт	<b>12.7 тэрбум.төг</b> батлан даалт	<b>2.3 тэрбум.төг</b> батлан даалт	<b>2.7 тэрбум.төг</b> батлан даалт
<b>20.2 сая.төг</b> нэг зээлдэгчийн дундаж	<b>23.0 сая.төг</b> нэг зээлдэгчийн дундаж	<b>24.3 сая.төг</b> нэг зээлдэгчийн дундаж	<b>28.6 сая.төг</b> нэг зээлдэгчийн дундаж

Зураг 10 Батлан даалтын хэмжээ, тоо (бүс нутгаар)



Батлан даалтад хамрагдсан орон нутгийн 834 зээлдэгчийн 19.6 тэрбум төгрөгийн батлан даалтын 18.4 тэрбум төгрөг нь 780 зээлдэгчийн “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий малчдын зээлд, 1.2 тэрбум төгрөг нь 54 зээлдэгчийн ипотекийн зээлд гаргасан батлан даалт байна.

Хүснэгт 1 Зээл, батлан даалтын дүн, тоо (аймгаар)сая.төг

Аймаг	Батлан даалтын хэмжээ	Зээлийн хэмжээ	Нэг батлан даалтын дундаж хэмжээ	Шинээр гаргасан батлан даалтын тоо
Архангай	2,113.2	3,250.01	23.22	91
Баян-Өлгий	0.0	0.0	0.0	0
Баянхонгор	4,828.2	6,154.77	23.21	208
Булган	1,917.3	3,222.13	24.58	78
Говь-Алтай	1,305.7	2,454.70	19.78	66


Говьсүмбэр	40.00	50.00	40.00	1
Дархан-Уул	67.44	374.18	22.48	3
Дорноговь	142.90	255.00	28.58	5
Дорнод	706.13	2,281.00	24.35	29
Дундговь	1,009.84	1,490.80	21.95	46
Завхан	80.00	150.00	20.00	4
Орхон	459.64	2,233.60	20.89	22
Өвөрхангай	355.70	659.90	19.76	18
Өмнөговь	300.40	645.50	27.31	11
Сүхбаатар аймаг	0	0	0	0
Сэлэнгэ	20.00	20.00	20.00	1
Төв	725.89	1,180.00	25.92	28
Увс	474.42	782.3	22.59	21
Ховд	40.20	65.00	13.40	3
Хөвсгөл	3,006.81	5,254.2	22.44	134
Хэнтий	1,978.31	2,394.1	30.44	65
<b>Нийт</b>	<b>19,572.00</b>	<b>32,917.1</b>		<b>834</b>

### Батлан даалт, зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэл

2025 оны жилийн эхний улирлын байдлаар нийт гаргасан батлан даалтын 0.7 хувийг мэдээлэл холбоо, 1.9 хувийг бөөний болон жижиглэн худалдааны үйл ажиллагаа, 4.8 хувийг боловсруулах үйлдвэр, 92.5 хувийг бусад салбар тус тус эзэлж байна. Тайлант хугацаанд нийт 841 зээлдэгчийн 36.48 тэрбум төгрөгийн зээлд 21.2 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан ба үүний дийлэнх буюу 92.9 хувь болох 781 Шинэ хоршоо хөдөлгөөний малчин иргэдэд 18.5 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан байна. Мөн 6.4 хувь болох 54 иргэнд 1.2 тэрбум төгрөгийн Ипотекийн зээлийн батлан даалт гаргасан байна.

Зураг 11 Батлан даалтын бүтэц (үйл ажиллагааны чиглэлээр)

Мэдээлэл, холбоо



Бөөний болон жижиглэн худалдаа



Боловсруулах Үйлдвэр



Бусад




### Зээлдүүлэгч болон батлан даалтын эх үүсвэр

Тайлант хугацаанд доорх 7 арилжааны банкны зээлд батлан даалт гаргасан ба Хаан банкны 16.9 тэрбум төгрөгийн зээлд 11.6 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан нь нийт батлан даалтын 54.8 хувийг эзэлж байна. Төрийн банкны 11 тэрбум төгрөгийн зээлд 7 тэрбум төгрөгийн, Худалдаа хөгжлийн банкны 2.8 тэрбум төгрөгийн зээлд 528.3 сая төгрөгийн, Капитрон банкны 3.4 тэрбум төгрөгийн зээлд 1.5 тэрбум төгрөгийн, Голомт банк, Хас банк, Ариг банк зэрэг

санхүүгийн байгууллагуудын 2.3 тэрбум төгрөгийн зээлүүдэд 599 сая төгрөгийн батлан даалт тус тус гаргасан байна. Хамгийн их батлан даалттай зээл олгосон Хаан банкны хувьд хоршооны гишүүн малчдад олгосон зээлийн батлан даалтын хэмжээ 11.5 тэрбум төгрөг байгаа нь тухайн банканд гаргасан батлан даалтын 98.7 хувийг эзэлж байна.


Зураг 12 Батлан даалтын хэмжээ (банкаар)



Эх үүсвэрийн хувьд авч үзвэл тайлант үеийн хугацаанд гарсан нийт батлан даалтын 87.1 хувь буюу 18.5 тэрбум төгрөгийг “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд төсвийн хөрөнгөөр

санхүүжүүлсэн бол 7.2 хувийг Азийн хөгжлийн банкны МОН-3338 төсөл, 5.4 хувийг ипотек, үлдсэн 0.3 хувийг ЖДҮХС-ын төслийн зээл зэрэг эх үүсвэрээс тус тус санхүүжүүлжээ.

Зураг 13 Батлан даалтын бүтэц (эх үүсвэрээр)



### Зээлийн болон батлан даалтын чанар

Батлан даасан нийт зээлийн үлдэгдлийг харвал нийт 14,248 зээлдэгчийн 761.8 тэрбум төгрөгийн зээл хэвийн ангилалд байгаа нь нийт зээлийн багцын 97.3 хувийг эзэлж байна. Ангилал буурсан зээлийн хувьд 14 зээлдэгчийн 3.9 тэрбум төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, 51 зээлдэгчийн 17.1 тэрбум төгрөгийн чанаргүй зээл байна. Харин Батлан даалтын чанарыг харвал 14,248 зээлдэгчийн 437.7 тэрбум төгрөгийн батлан даалт хэвийн, 20 зээлдэгчийн 3.9 тэрбум төгрөгийн батлан даалт хугацаа хэтэрсэн, 45 зээлдэгчийн 5.9 тэрбум төгрөгийн батлан даалт чанаргүй ангилалд байна.

Зураг 14 Батлан даалтын чанар (хувиар)




Зураг 15 Зээлийн чанар (хувиар)



2025 оны эхний улирлын нийт батлан даалтад эзлэх чанаргүй батлан даалтын хэмжээ 1.3 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.0 пунктээр бага үзүүлэлт юм. Нийт батлан даалтын хэмжээ нэмэгдсэн нь чанаргүй батлан даалтын эзлэх хувь буурахад шууд


нөлөөлж байгаа ч чанаргүй батлан даалтын тоо мөн буурсаар байгаа нь батлан даалтын чанарт сайнаар нөлөөлж байна.

Зураг 16 Чанаргүй батлан даалтын хувь, зээлдэгчдийн тоо



Тайлант хугацаанд зээлдүүлэгчдээс чанаргүй 62 зээлийн үүргийг хангуулахаар 8.2 тэрбум төгрөгийг нэхэмжилсэн ба Зээлийн батлан даалтын сангаас 7.5 тэрбум төгрөгийн үүргийг гүйцэтгэж, эргээд 46 зээлдэгчээс 1.5 тэрбум төгрөгийн авлагыг төлүүлсэн байна. Батлан даалтын үүргийн гүйцэтгэлийн сүүлийн 4 жилийн статистикийг харвал зээлдүүлэгчдээс нэхэмжилсэн дүн дунджаар 53 хувиар, үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын дүн дунджаар 48 хувиар нэмэгдсээр байна.


Зураг 17 Үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын дүн, тоо



Харин үүрэг гүйцэтгэсэн батлан даалтын авлагын төлөлтийг харвал 2025 оны эхний улирлын байдлаар нийт 46 зээлдэгч 1.5 тэрбум төгрөгийг Батлан даалтын санд төвлөрүүлжээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 50 хувиар нэмэгдсэн үзүүлэлт юм. 2021-2025 онуудын авлагын мэдээг харвал Батлан даалтын санд төлөгдсөн авлагын дүн жилд дунджаар 1.5-2 дахин өссөн байна. 2025 оны эхний улирлын байдлаар үүрэг


гүйцэтгэсэн батлан даалттай холбоотойгоор нийт 62 зээлдэгчийн 6 тэрбум төгрөгийн авлагын үлдэгдэл байна.

Зураг 18 Төлөгдсөн авлагын хэмжээ



Тайлант хугацаанд чанаргүй батлан даалтын үлдэгдлээс эдийн засгийн үйл ажиллагааны салбараас авч үзвэл 50.2 хувь нь тээвэр агуулахын үйл ажиллагаа, 23.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, 9.6 хувь нь барилга, 5.0 хувь нь удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, 3.1 хувь нь мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт, 2.8 хувь нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйл ажиллагаа, 2.6 хувь нь боловсролын салбарт, 3.2 хувь нь бусад салбарт олгосон батлан даалтууд бүрдүүлж байна.

Зураг 19 Чанаргүй батлан даалтын үлдэгдэл (үйл ажиллагааны чиглэлээр)



## ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 46 дугаар тогтоолоор баталсан “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-ын дагуу Зээлийн батлан даалтын сан нь дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллахаар зохицуулсан байдаг. Үүний дагуу 2024 оны жилийн эцсийн байдлаар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг харвал нийт 12 шалгуур үзүүлэлтийг бүгдийг нь хангасан байна.

Хүснэгт 2 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР	ХАНГАСАН ЭСЭХ
<b>ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>			
Өөрийн хөрөнгийн байвал доод хэмжээ	5,000,000,000.00	100,817,371,703.00	Хангасан
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт	10%-аас доошгүй	33.2%	Хангасан
Гаргасан төлбөрийн баталгаа өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10 дахин нэмэгдүүлснээс хэтрэхгүй	447,645,546,540.09	Хангасан
<b>ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА</b>			
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	100%-аас доошгүй	123%	Хангасан
<b>АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	60%	Хангасан
Хоршооны гишүүн малчинд гаргах батлан даалт, зээлийн зохистой харьцаа	100%-аас хэтрэхгүй	100%	Хангасан
Нэг зээлдэгчид гаргах батлан даалт, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	1.2%	Хангасан
Өөрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	40%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
Урт хугацаат өөрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА</b>			
Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	14.1%	Хангасан
<b>ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ</b>			
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	5%-аас хэтрэхгүй	1.4%	Хангасан
<b>НӨӨЦИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ</b>			
Нөөцийн сангийн хүрэлцээний үзүүлэлт	2,134,740,260.64	22,944,837,052.59	Хангасан
<b>ЧАНАРГҮЙ БАТЛАН ДААЛТЫН ҮЛДЭГДЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА</b>			
Чанаргүй батлан даалтын үлдэгдлийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	1.3%	Хангасан

## САНАЛ, ДҮГНЭЛТ

2025 оны 1 дүгээр улирлын байдлаар Зээлийн батлан даалтын сангийн нийт хөрөнгө 303.4 тэрбум төгрөгт хүрч, 2024 оны мөн үеэс 3.4 хувиар өссөн бол нийт орлогын хэмжээ 2.8 тэрбум төгрөгт хүрлээ.

Тайлант үеийн хугацаанд шинээр 841 зээлдэгчийн 36.5 тэрбум төгрөгийн зээлд 21.2 тэрбум төгрөгийн батлан даалт гаргаж, 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн тайлангаар нийт 14,313 зээлдэгчийн 782.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлд 447.6 тэрбум төгрөгийн батлан даалтын үлдэгдэл бүртгэсэн байна.

Тайлант үеийн хугацаанд Улаанбаатар хотын 7 зээлдэгчийн 3.6 тэрбум төгрөгийн зээлд 1.7 тэрбум төгрөгийн, орон нутгийн 834 зээлдэгчийн 32.9 тэрбум төгрөгийн зээлд 19.6 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан ба батлан даалтад хамрагдсан зээлдэгчдийн 99.4 хувь нь иргэн, 0.6 хувь нь хуулийн этгээд байна. Улаанбаатар хотын хувьд Хан-Уул дүүрэгт хамгийн их буюу 3 зээлдэгчид 1.2 тэрбум төгрөгийн батлан даалт гаргасан бол орон нутагт Баянхонгор аймагт хамгийн их буюу 208 зээлдэгчид 4.8 тэрбум төгрөгийн батлан даалт гаргажээ.

Зээлийн батлан даалтын сангаас 2025 оны эхний улирлын байдлаар нэр бүхий 7 арилжааны банкны зээлд батлан даалт гаргасан ба хамгийн их батлан даалттай Хаан банкны хувьд “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд хоршооны гишүүн малчдад олгосон зээл тухайн банканд гаргасан батлан даалтын 98.7 хувийг эзэлж байна.

Тайлангийн хугацаанд шинээр гаргасан батлан даалтын 87.1 хувь буюу 18.5 тэрбум төгрөгийг “Шинэ хоршоо хөдөлгөөн”-ий хүрээнд төрөөс төсвийн хөрөнгөөр, үлдсэн 12.9 хувийг бусад эх үүсвэрээс санхүүжүүлсэн байна.

Батлан даасан зээлийн чанарыг харвал 14,248 зээлдэгчийн 437.7 тэрбум төгрөгийн зээл хэвийн, 65 зээлдэгчийн 9.9 тэрбум төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн болон чанаргүй ангилалд шилжиж нийт зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээ 2.2 хувь болж нийт батлан даалтад эзлэх чанаргүй батлан даалтын хувь 1.3 хувь болж буурчээ. Сүүлийн 4 жилийн батлан даалтын үүргийн гүйцэтгэлийн мэдээгээр зээлдүүлэгчдээс нэхэмжилсэн дүн, үүрэг гүйцэтгэсэн дүн дунджаар 48-53 хувиар нэмэгдэж байгаа тул зээлийн болон батлан даалтын чанарт онцгой анхаарах хэрэгтэй байна.

Шинээр батлан даасан зээлдэгчдийн үйл ажиллагааны чиглэлийг харвал 1.9 хувийг бөөний болон жижиглэн худалдааны бизнес эрхлэгчид, 4.8 хувийг боловсруулах үйлдвэр, 0.7 хувийг мэдээлэл холбоо, үлдсэн 92.5 хувийг бусад салбар эзэлж байна. Бусад салбарын дийлэнх хэсгийг Шинэ хоршоо хөдөлгөөн болон ипотекийн батлан даалт эзэлж байна. Тиймээс эдийн засгийн бусад салбарт тэр дундаа нэмүү өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, үйлчилгээ эрхлэгчдэд батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.